



[www.sankhuuginbolovsrol.mn](http://www.sankhuuginbolovsrol.mn)

# БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ӨСӨЛТ БА ВАЛЮТЫН ХАНШ

# 1. ҮНИЙ ӨСӨЛТ БА АМЬЖИРГААНЫ ӨРТГИЙН УЯЛДАА ХОЛБОО

Ажил эрхлэлт, улсын эдийн засгийн байдал, зээлийн хүүний түвшин, мөнгөний нийлүүлэлт гэх мэт биднээс хамаарахгүйгээр өөрчлөгдөж, эргээд бидний амьдралд нөлөөлдөг хүчин зүйлс байна. Эдгээрээс бидний өдөр тутмын амьдралд, амьжиргаанд хамгийн их нөлөө үзүүлдэг хүчин зүйлийн нэг нь **инфляци юм.**

**Инфляци: үнийн ерөнхий түвшний өсөлтийг харуулсан үзүүлэлт юм.**

Инфляцийг бид хялбараар бараа, үйлчилгээний үнийн өсөлт, мөнгөний худалдан авах чадварын бууралт гэж ойлгож болно.



# 1. ҮНИЙ ӨСӨЛТ БА АМЬЖИРГААНЫ ӨРТГИЙН УЯЛДАА ХОЛБОО

- Хэрэв инфляцигүй байвал юмны үнэ өөрчлөгдөхгүй.
- Инфляци өсөхөд мөнгөний худалдан авах чадвар буурч, барааны үнэ өсдөг.
- Инфляцийг зөвхөн нэг барааны үнийн өсөлтөөрөө биш нийт бараа, үйлчилгээний үнийн дундаж түвшний өсөлтөөр хэмжинэ.

Инфляци танд сонголт өгнө. Гэхдээ...

Мөнгөөрөө хоол, хүнс авах уу

Хүүхэддээ гутал авах уу

Сонголтоо өөрөө хий!!!



- Инфляци өсөхөд айл өрхийн олж байгаа орлого буюу мөнгөнийх нь худалдан авах чадвар буурна.

Жишээ нь: Инфляци 25 хувиар өсөхөд 1000 төгрөгийн худалдан авах чадвар 25 хувиар буурна.



Талхны 4-ний 1 нь хааччихав аа???

## 2. ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ БИДНИЙ АМЬДРАЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛДӨГ ВЭ?

Өдөр тутмын амьдрал, санхүүгийн байдалд нөлөөлж байдаг өөр нэг хүчин зүйл – ВАЛЮТ.

- **Валют** - гадаад, дотоод төлбөр тооцоонд хэрэглэгдэж байгаа аль нэг улсын мөнгөн тэмдэгтийг хэлнэ.
- **Валютын ханш** - аль нэг улсын валютыг өөр нэгэн улсын валютаар илэрхийлсэн үнэ.



# ВАЛЮТЫН ХАНШИЙГ ХЭН ТОГТООДОГ ВЭ?

## Банк болон Банк бус санхүүгийн байгууллага



Валютын эрэлт хэрэгцээнд худалдах, худалдан авах өөрийн ханшийг тогтооно.

## МОНГОЛБАНК



Валютын зах дээр арилжааны банкуудын худалдсан, худалдаж авсан гадаад валютын ханшид үндэслэн тухайн өдрийн албан ханшийг тогтооно. Албан ханшийг шүүх, гаалийн тооцоо болон нягтлан бодох бүртгэлд ашиглана.

# ВАЛЮТЫН ХАНШИЙГ ХЭН ТОГТООДОГ ВЭ?

Валютын ханшийн өөрчлөлт бараа, үйлчилгээний үнээр дамжин иргэдийн амьжиргаанд нөлөөлдөг. Хэрэв гадаад валютын ханш өсвөл гадаадаас импортоор оруулж байгаа бүх барааны үнэ нэмэгдэнэ. Хялбар жишээ:

Хугацаа	Ам.долларын албан ханш	Гадаад зах зээлээс худалдан авсан бараа	Ам.доллараар илэрхийлэгдсэн үнэ	Төгрөгөөр илэрхийлэгдсэн үнэ
2015-01-01	1888	1 кг чихэр	2 ам.доллар	3776 төг
2016-01-01	1995	1 кг чихэр	2 ам.доллар	3990 төг

- ❖ Гадаад валютын ханшийн өсөлт валютаар худалдан авдаг бүх бараа, үйлчилгээний үнэд нөлөөлж, улмаар инфляцийг нэмэгдүүлдэг.
- ❖ Гадаадад бараа, бүтээгдэхүүнээ гаргаж худалдаж байгаа байгууллага, иргэдийн хувьд гадаад валютын ханшийн өсөлтөөс хамаарч орлого, ашиг нь нэмэгддэг.
- ❖ Гадаад валютын хадгаламжтай иргэдийн хувьд ашигтай.



**Баярлалаа**